



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН СОНГУУЛИЙН
БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАМААР ОРОЛЦООГ
НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2012 ОН**

Гарчиг

Талархал	2
Оршил	2
Төслийн танилцуулга	3
Төслийн үндэслэл	4
Төслийн зорилт	5
Үйл ажиллагаа нэг:	6
Үйл ажиллагаа хоёр:	11
Үйл ажиллагаа гурав:	16
Үйл ажиллагаа дөрөв:	19
Дүгнэлт:	29
Зөвлөмж:	32

Товчилсон үгийн жагсаалт

1. МУ-----Монгол Улс
2. НҮБ----- Нэгдсэн Үндэсний Байгууллага
3. ХБ----- Хөгжлийн Бэрхшээл
4. ХБХ-----Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүс
5. ХЭҮК----- Хүний Эрхийн Үндэсний Комисс
6. СЕХ----- Сонгуулийн Ерөнхий Хороо
7. СБТ----- Сонгогчийн Боловсрол Төв
8. УИХ----- Улсын Их Хурал
9. ХЗДХЯ-----Хууль Зүй Дотоод Хэргийн Яам
10. ОУБ-----Олон Улсын Байгууллага
11. ТББ ----- Төрийн Бус Байгууллага
12. МТИҮХ-----Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний холбоо
13. МХБИЧҮЭ----- Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Чөлөөт
- Үйлдвэрчний Эвлэл
14. ХБИБИТ----- Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Бизнес Инкубатор Төв
15. МХҮХ-----Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо
16. МХБИБҮХ-----Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн
Байгууллагуудын Үндэсний Холбоо

ТАЛАРХАЛ

Formatted: Indent: Left: 0"

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн /ХБХ/ улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг баталгаажуулах, тэдний сонгуулийн боловсролыг дээшлүүлэх замаар сонгох, сонгогдох эрхээ эдлэх боломжийг нь нэмэгдүүлэх санаачлага гаргаж буй АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Мерси Кор Монгол олон улсын байгууллага, /ОУБ/ Иргэдийн оролцоо засаглалын хөтөлбөрийн хамт олонд талархаж байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд аргагүйн зөвлөмжөөр ханган ажиллаж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн бодлогын шийдвэр гаргагчдад олон талын байр суурийг харьцуулах боломжийг олгосон Сонгуулийн Ерөнхий Хорооны /СЕХ/ хамт олонд ажлын амжилт хүсье

Бидний нөлөөллийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцон ХБХ-ийн сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг арилгах, асуудлыг төр засаг, олон нийтийн хэмжээнд дэвшүүлэн тавихад хамтран ажилласан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Хүртээмжтэй орчин” аянд нэгдсэн төрийн бус байгууллагууд, /ТББ/ Өвөрхангай аймгийн Хуульч залуучуудын холбоо, Баянхонгор аймгийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Нэгдсэн Төв, Архангай аймгийн Тэргэнцэртэй Иргэдийн Холбоо, Увс аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Тэгш Оролцоо” ТББ, Дундговь аймгийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Зөвлөл, Дархан-Уул аймгийн Тэргэнцэртэй Иргэдийн Холбоо, болон Хүний Эрхийн Үндэсний Комисс /ХЭҮК/, Сонгогчдын Боловсрол Төв /СБТ/, Нээлттэй Нийгэм Форум /ННФ/, “Шудрага сонгуулийн төлөө гараа өргөцгөө” залуусын аян, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ТББ зэрэг төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн байгууллагын хамт олонд гүн талархал илэрхийлье !

ОРШИЛ-

Монгол Улсад 2010 оны жилийн эцсийн байдлаар нийт 83,631 ХБХ байгаа нь нийт хүн амын 2,97 хувийг эзэлж байна. Нийт ХБХ-ийн 45,8%-нь эмэгтэй, 1%-нь 16-аас доош насны хүүхэд байна.^{i ii}

2008 онд Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбооны /МХБИБҮХ/ хийсэн судалгаагаар сонгуулийн насны санал өгөх эрхтэй 39265 ХБХ байгаа ба 2008 оны УИХ-ын сонгуульд дээрхи иргэдийн 34,7 % буюу дөнгөж 13625 хүн оролцсон гэсэн судалгаа гарсан нь тун хангалтгүй үзүүлэлт юм.

¹ Эх үүсвэр: 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр МХБИБҮХ-ны хийсэн судалгаанаас

² CRPD_Report_mn / page 47/

Мерси Кор Монгол ОУБ нь 2008 оны сонгуульд ХБХ-ийн оролцоо хэр байсан талаар 10 аймгийн 200 ХБХ-ийн дунд судалгаа явуулахад ХБХ-ийн сонгуульд оролцох оролцоо нь сул биш байсан боловч санал өгөх байрны орц гарцын хүртээмжгүй байдал, дараалал хүлээхэд суух сандал байхгүй, зөөврийн саналын хайрцаг ирдэггүй зэрэг асуудлууд гарчээ.

Монгол Улс Нэгдсэн Үндэсний Байгууллагаас батлан гаргасан ХБХ-ийн Эрхийн тухай конвенцид 2009 онд нэгдэн орсон. Тус конвенцийн 29-р зүйлд ХБХ-ийн улс төр нийгмийн амьдралд оролцох эрхийг баталгаажуулан:

сонгууль өгөх журам, байр, сонгуулийн хуудас нь ашиглахад зохистой хүртээмжтэй болон ойлгох, ашиглахад хялбар байх явдлыг хангах;

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгууль болон ард нийтийн санал асуулгад ямар нэг сүрдүүлэггүйгээр саналаа нууцаар өгөх, ...

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгогчийн хувьд өөрийн санал, бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үүний тулд шаардлагатай тохиолдолд тэдгээр хүмүүсийн хүсэлтээр сонгосон хүний тусалцаатайгаар саналаа өгөх. хэмээн тус тус заасан байдаг.

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр Мерси Кор Монгол ОУБ-аас хэрэгжүүлж буй "Орон Нутгийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдэд Ээлтэй Орчин Бүрдүүлэх нь -2" /ФИЕЛД/ төслийн хүрээнд ХБХ-ийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, ХБХ-ийн ТББ-уудын сонгуулийн үйл ажиллагаанд хяналт тавих чадавхийг нэмэгдүүлэх, 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн санал авах байрны дэд бүтцийн хүртээмжтэй байдлыг ХБИ-нд тохиромжтой байдлаар зохион байгуулахад нөлөөлөл үзүүлэх зорилго бүхий богино хугацааны төслийг 2012 оны 05 сарын 11-нээс 07 сарын 31-ны хугацаанд хэрэгжүүллээ.

Энэхүү үйл ажиллагаа нь Өвөрхангай, Архангай, Дундговь, Баянхонгор, Увс, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын 3246 орчим хүнийг хамарсан бол бусад аймаг, хотуудад байх ХБХ-т олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан үйл ажиллагааг хүргэлээ.

Төслийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ СЕХ, ХЭҮК, СБТ, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ТББ, ННФ, "Шудрага сонгуулийн төлөө гараа өргөцгөө" залуусын аян, зэрэг гол сонирхогч талууд болон иргэдийн сонгуулийн боловсролыг нэмэгдүүлэх, оролцоог хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, иргэний нийгмийн

байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллалаа.

НҮБ-аас батлан гаргасан ХБХ-ийн Эрхийн тухай конвенцид МУ нэгдэн орсонтой холбогдуулан конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд нөлөөлөл үзүүлэх зорилгоор ХБХ-ийн ТББ-уудаас “Хүртээмжтэй орчин” аяныг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай. Сонгуулийн жилтэй холбогдуулан тус аян энэ жил “Хүртээмжтэй орчин 2012-Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуулийн тэгш оролцоо” уриан дор зохион байгуулагдсан.

Манай төсөл нь “Хүртээмжтэй орчин” аянтай үйл ажиллагаагаа нэгтгэн хамтран ажилласан бөгөөд тус аяны ажлын хэсгийн ахлагч, Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Бизнес Инкубатор Төвийн /ХБИБИТ/ захирал Б. Гүнжилмаа аяны болон төслийн үйл ажиллагааг сайтар уялдуулан, ажлыг үр дүнтэй болгоход хичээл зүтгэл гарган ажиллав. Төслийн зөвлөхөөр МТИҮХ-ны тэргүүн Б. Чулуундолгор ажиллаж төсөлд оролцогч ТББ-ын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, ажлын аргачлал, мэдээллээр хангах, үйл ажиллагааг нэгтгэн дүгнэх, асуудлыг олон нийт болон төр засгийн хэмжээнд дэвшүүлэн тавих ажлыг хариуцан ажиллав.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Санал авах байр хүртээмжгүй, ХБХ-ийн сонгуультай холбоотой хууль эрх зүйн мэдлэг дутмаг, тэдний сонгуульд оролцох идэвхи оролцоо сул байгаагийн дээр, санал авах байр, саналын хуудас, нэр дэвшигч нар болон намуудын мөрийн хөтөлбөр ХБХ-т хүртээмжгүй байгаа, саналын хуудас брайлиар хэвлэгдээгүй буюу шоблом байхгүй гэсэн шалтгаанууд нь ХБХ-ийн сонгуульд бүрэн дүүрэн оролцох, эрхийг хязгаарлаж байна. Мөн 2012 оны УИХ-ын сонгуулиар Улсын Их Хурлын 76 гишүүний 48-ийг нь олон мандаттай томсгосон тойргоос, үлдсэн 28-ийг нь нам, эвслийн нэрийн жагсаалтаас нам, эвслийн нэрээр сонгох буюу мажоритар, пропорциональ хосолмол тогтолцоогоор явагдах болсон, сонгуулийн санал хураах, тоолох ажлыг автоматжуулсан төхөөрөмжөөр гүйцэтгэх, анх удаа УИХ, орон нутгийн сонгууль зэрэг явагдах зэрэг олон онцлог талуудтай байлаа.

Иймд сонгогчдын сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, санал авах байрыг хүртээмжтэй болгох, шинээр батлагдсан Сонгуулийн тухай хуулийг сурталчилах, ХБХ-ийг сонгуульд бүрэн дүүрэн оролцоход тулгарч буй асуудлыг төр засаг, олон нийтийн хэмжээнд дэвшүүлэн тавьж шийдвэрлүүлэх

замаар ХБХ-ийн улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг баталгаажуулах богино хугацааны

Төслийн зорилго:

ХБИ-ийн сонгуулийн боловсролыг нэмэгдүүлэх замаар тэдгээрийн сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх, тулгамдаж буй асуудлыг төр засгийн хэмжээнд тавьж шийдвэрлүүлэхэд нөлөөлөл үзүүлэх.

Төслийн үйл ажиллагаа:

1. ХБХ-ийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, сургалт, мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулах
2. Санал авах байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, сонгогчийн нэрсийн жагсаалтанд тулгалт хийх
3. Сонгууль өгөх үйл явцад иргэдийн оролцоог хангах, сонгуулийн өдрийн үйл ажиллагаанд хяналт, мониторинг хийх
4. ХБХ-ийн сонгуулийн оролцоог нэмэгдүүлэхэд тулгарч буй асуудлыг төр засаг олон нийтийн хэмжээнд тавьж шийдвэрлүүлэхэд нөлөөлөх, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хүргэх

Үйл ажиллагаа 1:

1. **ХБХ-ийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, сургалт, мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулах.**

ХБХ-ийн ТББ-уудыг чадваржуулан, тэдгээрийг гишүүддээ хүрч ажиллах боломжоор хангах замаар нийт ХБХ-ийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг Сонгогчдын боловсрол төв, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ТББ-тай хамтран 2012 оны 05 сарын 15-ны өдөр зохион байгуулав. Тус сургалтанд Улаанбаатар хотын ХБИ-ийн 8 ТББ-ын 11 гишүүн оролцож сонгуультай холбоотой хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж, сонгуулийн үйл ажиллагаанд хяналт мониторинг хийх аргачилал, сонгуульд иргэдийн оролцоог хангах чиглэлээр хэрхэн нөлөөллийн ажил хийх талаар туршлага мэдлэгийг олж авсан юм. Үүнд: Иргэдийн улс төрийн оролцоог хангахын тулд нэн түрүүн хийгдэх ажлууд, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх арга хэлбэрүүд, сонгогчдын эрхийг хангах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх кампанит ажлын төлөвлөгөө гаргах тухай болон өмнөх жилүүдийн сонгуулийн үеэр иргэний нийгмийн байгууллагуудын хийсэн нөлөөллийн ажил, хяналт ажиглалт, болон зохион байгуулсан кампанит ажлын туршлагаудтай танилцлаа.

Сургалтын үр дүнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХБХ-ийн ТББ-ын төлөөллүүд сонгуульд ХБХ-ийн оролцоог хангах, санал авах байрны

хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, сонгогчдын сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн өдөр ажиглалт хийх зэрэг бүхий л үйл ажиллагааг хуулийн хүрээнд, зөв, хийж гүйцэтгэх чадварыг эзэмшсэн юм.

Сургалтыг Сонгогчдийн боловсрол төвийн захирал С. Оюунтуяа, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөний Ж. Чанцалдулам нар удирдан явууллаа.

Сургалтын сэдэв:

№	Хичээлийн сэдэв
1	2011 оны 12 сарын 15-ны өдөр шинэчлэн найруулсан сонгуулийн шинэчилсэн хуулийн үзэл баримтлал
2	2012 оны сонгуулийн онцлог
3	Сонгогч саналаа өгөх журам, аргачилсан заавар
4	Сонгогчдийг нэрсийн жагсаалтанд бүртгүүлэх
5	Зөөврийн харйцагаар санал өгөх журам
6	Сонгуулийн ажиглагчийн эрх үүрэг

Сургалтанд хамрагдаж чадваржсан ТББ-ын төлөөллүүд “Хүртээмжтэй орчин 2012-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн тэгш оролцоо” аяны ажлын хэсэгт нэгдэн орж ХБХ-ийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, оролцоог хангах, тулгамдаж буй асуудлыг төр, олон нийтийн анхааралд оруулж шийдвэрлүүлэх ажлыг хамтран багараа ажиллах шийдвэрт хүрсэн.



Мөн төслийн баг Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ТББ, Сонгогчдын боловсрол төвийн хамтран хэрэгжүүлж байгаа “Сонгуульд иргэдийн оролцоо” хөтөлбөрийн танилцуулга уулзалтанд оролцож хөтөлбөрийн үйл ажиллагаа хэрэгжилт, хийгдсэн судалгааны тайлантай

танилцав. Сонгогчын боловсрол төвөөс намуудын ажиглагч нарт зориулан явуулсанд сургалтанд оролцож, сонгуулийн ажиглагчийн эрхзүйн байдал, сонгуульд бэлтгэх үйл явцыг ажиглах, санал авах өдөр болон санал тоолох үйл явцыг ажиглах зэрэг үйл ажиллагааны дэс дараалал, арга техникээс суралцсан.

Төслийн үйл ажиллагааг орон нутагт хүргэх зорилгоор Архангай, Өвөрхангай, Дундговь, Баянхонгор, Дархан-Уул, Увс аймгуудын ХБХ-ийн байгууллагуудын дунд төслийн үндсэн зорилтын хүрээнд төслийн уралдааны зарыг 2012 оны 05 сарын 17-ноос 21-ний хугацаанд зарлав. Төслийн уралдаанд нийт 25 ТББ-ын 12 төсөл ирүүлсэнээс, 15 ТББ-ын хамтран хэрэгжүүлэх 7 төслийг шалгуурын дагуу сонгон шалгаруулав. Улаанбаатар хотод байх ХБХ-ийн ТББ-ууд хамтран нэг төслөөр оролцсон.

Шалгарсан төслүүд

№	Төслийн нэр	Харъяа аймаг, хот
1	“Хүртээмжтэй орчин” төсөл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 11 ТББ-хамтарсан баг
2	“Сонгох эрх” төсөл	Дархан-Уул аймгийн Тэргэнцэртэй иргэдийн холбоо
3	“Бидний эрхэм зэрэг” төсөл	Увс аймгийн Тэгш оролцоо ТББ
4	“Тэгш дүүрэн” төсөл	Баянхонгор аймгийн ХБИ-н нэгдсэн төв
5	“Сонгууль” төсөл	Архангай аймгийн тэргэнцэртэй иргэдийн холбоо
6	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх” төсөл	Өвөрхангай аймгийн Хуульч залуучуудын холбоо
7	“Оролцоо” төсөл	Дундговь аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл

Төсөлд шалгарсан орон нутгийн ТББ-ууд төслийн төв багаас өгсөн ажлын чиглэлийн дагуу орон нутаг дахь ХБ-тэй сонгогчдын сонгуулийн боловсролыг дээшлүүлэх сургалт мэдээллийн үйл ажиллагааг 2012 оны 06 сарын 05-наас 15-ны хугацаанд хийж гүйцэтгэв.

Сургалт мэдээлэлд Улаанбаатар хотод 91, төслийн 6 аймагт 581 нийт 672 ХБХ хамрагдлаа. Баянгол, Сүхбаатар дүүрэг болон Дархан-Уул аймаг мэргэжлийн багшийн оролцоотой сургалтаа явуулж үлдсэн аймаг дүүргүүд өөрсдийн сургагч багш нар болон нөөц дээр тулгуурлан сургалтыг зохион байгуулав. Дундговь аймагт танхимын сургалтаас гадна хэвтэрт байдаг, гэрээс гарах боломжгүй ХБХ-т гэрээр очиж мэдээлэл хүргэх үйл ажиллагааг зохион байгуулсан нь ихээхэн үр дүнтэй ажил боллоо. Мөн Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоотой /МХҮХ/ хамтран харааны бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд нийцсэн тусгай сургалтыг зохион байгуулж тус холбооны 30 гишүүн хамрагдав.



СХД-ийн сургалт



Дархан-Уул аймгийн сургалт



Дундговь гэрээр очиж мэдээлэл



Увс аймаг хүргэж байгаа нь

Сургалтанд хамрагдагсадын тоо аймаг, дүүргээр

Дархан-Уул аймаг	30	Баянхонгор аймаг	40
Сонгинохайрхан дүүрэг	21	Дундговь аймаг	40
Баянгол дүүрэг	20	Архангай аймаг	26
Сүхбаатар дүүрэг	20	Увс аймаг	410
Харааны бэрхшээлтэй иргэд	30	Өвөрхангай аймаг	15

Аймаг, дүүрэг тус бүр сургалтанд оролцсон идэвхитэй ХБХ-ээс сонгон **идэвхтэн туслагч нарын баг** бүрдүүлэн, тухайн орон нутаг дахь бусад ХБХ-ийг сонгогчийн нэрсийн жагсаалтанд бүртгүүлэх, саналын хуудас дээр ажиллах аргачилсан заавар, санал авах байрны байршилын мэдээлэл, 2012 оны сонгуулийн онцлогийг тайлбарласан мэдлэг мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулав. Төслийн хүрээнд нийт 72 идэвхтэн туслагч нар ажиллав.

Идэвхтэн туслагч нарын тоо аймаг дүүргээр


Дархан-Уул аймаг	9	Баянхонгор аймаг	12
Сонгинохайрхан дүүрэг	5	Дундговь аймаг	7
Баянгол дүүрэг	5	Архангай аймаг	6
Сүхбаатар дүүрэг	7	Увс аймаг	11
Харааны бэрхшээлтэй иргэд	5	Өвөрхангай аймаг	5



Архангай аймаг идэвхтэн туслагч нар Сонгогчийн нэрсийн жагсаалтанд тулгалт хийв



Өвөрхангай аймаг дахь идэвхтэн туслагч ХБ-тэй иргэнд мэдээлэл хүргэж байгаа нь



Мөн МХҮХ-той болон СЕХ-той хамтран харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сонгуулийн шинэчилсэн хууль, саналын хуудастай ажиллах арга гэх мэт сонгогчдод шаардлагатай бүх мэдээллийг багтаасан ярьдаг, аудио /Daisy/ номыг хэвлэн харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүргэсэн нь хэвлэмэл материал ашиглахад бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үр дүнтэй ажил боллоо.

Үйл ажиллагаа 2:

Санал авах байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, сонгогчийн нэрсийн жагсаалтанд тулгалт хийх


2.1: Санал авах байрны хүртээмж:

Улаанбаатар хот, орон нутгийн чадваржсан ТББ, тэдний идэвхтэн туслагч нарын оролцоотой санал авах байрны хүртээмжинд “Иргэний барилгын төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин” MNS 6055:2009 стандартын 4 үзүүлэлт болон, “Хүртээмжтэй орчин” аяны хүрээнд СЕХ-ноос Монгол Улсын Сонгуулийн 2012 оны сонгуулийн тойргийн хороодод 2012 оны 06 сарын 02 –ны өдөр хүргүүлсэн гурван ажлын чиглэлийн дагуу үнэлгээ хийв. Үнэлгээг 2012 оны 06 сарын 11-нээс 06 сарын 21-ний хугацаанд, Улаанбаатар хотын 3 дүүрэг, 5 аймгийг хамран нийт 50 санал авах байранд хийв.

Үнэлгээ хийсэн санал авах байруудын тоо аймаг, дүүргээр:

Дархан-Уул	9	Сонгинохайрхан	10
Баянхонгор	10	Баянгол	6
Архангай	4	Сүхбаатар	10

Санал авах байрны хүртээмжийн үнэлгээ графикаар



Comment [C1]: Графикаа эх хувиар нь явуулаарай

Үнэлгээгээр нийт санал авах байруудын 37%-нь хоёр болон түүнээс дээш давхарт, 10%-нь подвальд, 38%-нь засварын байдалтай, 15%-нь хүртээмжтэйгээр засварлан тохижуулагдсан байв.

Санал авах байранд хийсэн үнэлгээний зураг




Үнэлгээ хийх явцад сонгуулийн тойргийн хороодын ажилтан албан хаагчид санал авах байрны хүртээмжтэй болгох төсөв байхгүй, энэ ажил нь ихээхэн цаг хүч шаардана, мөн энэ асуудал нь бүх нийтэд хамаатай биш, зөвхөн ХБХ-ийн асуудал гэх мэтээр үл ойлгох хандлага ихээр гаргаж байв.

Төслийн баг дээрх нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор СЕХтой хамтран 2012 оны 06 сарын 26 –нд СЕХ-ноос Монгол Улсын Их Хурлын 2012 оны сонгуулийн 1069 тойргийн хороодын дунд зохион байгуулсан **Online** хуралд оролцон санал бэлтгэх байрыг хүртээмжтэй болгох стандартын мэдээлэл хүргэх, зурагт хуудсыг илгээх ажлыг зохион байгууллаа. Мөн өдөр төсөл хэрэжиж буй Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянгол, Сүхбаатар дүүргийн сонгуулийн тойргийн 3 хороо, 10 хэсгийн хороон дээр нийт 13 удаагийн уулзалт зохион байгуулж, тэдний ажилтан албан хаагчид нийт 91 хүнд мэдээллийг хүргэж санал бэлтгэх байрыг хүртээмжтэй болгох чиглэлээр уулзалт ярилцлага зохион байгуулав.



Орон нутгийн төслийн багийнхнаас гарсан санаачлагын дагуу аймаг бүрт 1-2 загвар санал авах байрыг хүртээмжтэйгээр засварлан тохижуулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэ үйл ажиллагаагаараа бид сонгуулийн хэсгийн хороод, төрийн албан хаагчид болон олон нийтэд эерэг хандлага төлөвшүүлэх, хүртээмжтэй байдал гэдэг нь зөвхөн ХБХ-ийн асуудал биш гэсэн ойлголтыг нийт иргэдийн дунд бий болгох зорилгыг агуулсан юм. Ажлын дүнд орон нутгийн 5 аймагт нийт 10 санал авах байрыг хүртээмжтэй болгон засварлан тохижууллаа.



Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан, товгор тод замыг санал авах байруудад хийж байгаа нь



Зөөврийн налуу зам хийж байгаа нь


2012 оны 6 сарын 28 буюу сонгуулийн өдөр хэрэгжсэн төслийн нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнг тооцох, СЕХ-ноос гаргасан ажлын чиглэлийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор санал авах байрны хүртээмжинд дахин үнэлгээ хийсэн юм.

Энэ удаагийн үнэлгээнд орон нутгийн 54, Улаанбаатар хотын 39 нийт 94 санал авах байрны хүртээмжинд үнэлгээ хийв.

Үнэлгээ хийсэн санал авах байруудын тоо аймаг, дүүргээр.

Дархан-Уул	26	Сонгинохайрхан	7
Увс	7	Баянгол	3
Баянхонгор	10	Сүхбаатар	3
Архангай	4	Чингэлтэй дүүрэг	23
Дундговь	9	Өвөрхангай	2

Үнэлгээгээр нийт санал авах байрны 60 %-нь хүртээмжтэй, 28%-нь хоёр болон түүнээс дээш давхарт, 15%-нь стандарт бус , 8% подвальд гэж гарчээ.



Үнэлгээний дүнгээс харахад санал авах байрны хүртээмжтэй байдал 32,6%-иар сайжирсан нь манай төслийн нөлөөллийн ажил үр дүнг харуулж байна. Зөвхөн дэд бүтцийн хүртээмж сайжраад зогсохгүй —ХБХ, өндөр настануудыг дараалал харгалзахгүй оруулах, хүлээлгийн сандал тавих, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулж томруулдаг шил байршуулах, иргэдэд ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээг хийх зэрэг ажлууд хангалттай сайн хийгдсэн байв. Төсөл хэрэгжсэн аймаг, дүүргүүдэд санал авах байрыг хүртээмжтэй болгохдоо түр зам хийсэн байдал ихээр ажиглагдав. Мөн Увс, Баянхонгор аймгуудад хоёр болон түүнээс дээш давхарт байрласан засвар хийх боломжгүй байруудад ХБХ, өндөр настануудад туслах туслагч нарыг ажиллуулсан сайн туршлага гарч байв.




2.2: Сонгогчийн нэрсийн жагсаалтанд тулгалт хийх

Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэх журмын дагуу төсөл хэрэгжсэн 5 аймаг, 3 дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдийн нэрсийн жагсаалтанд тулгалт хийх үйл ажиллагааг орон нутаг, дүүрэгт ажилласан идэвхтэн туслагч нарын оролцоотой хэрэгжүүлэв.

Орон нутаг, дүүргийн ХХҮХ, Нийгмийн даатгалын хэлтэс, өрхийн эмнэлэг болон ХБХ-ийн ТББ-уудад байгаа нэрсийн жагсаалтанд тулгуурлан нийт 5019 сонгогчийн нэрсийн жагсаалтанд тулгалт хийв. Үүнээс бичиг баримтын зөрчилийн улмаас сонгуульд оролцох эрх үүсээгүй 32 иргэнийг илрүүлж, бичиг баримтаа бүрдүүлж дараагийн сонгуульд оролцох тухай зөвлөв. Сонгогчийн нэрсийн жагсаалтанд огт бүртгэгдээгүй 31 ХБИ-ийг илрүүлэн сонгогчын нэрсийн жагсаалтанд бүртгүүлсэн бол, орон нутгийн 4 аймагт зөөврийн хайрцагаар санал өгөх 305 иргэний бүртгэлийг гарган хэсгийн хороодод хүргэжээ.

Илэрсэн зөрчил графикаар



Нэрсийн жагсаалтанд тулгалт хийгдсэн байдал

№	Аймаг дүүргийн нэр	Тулгалт хийсэн хүний тоо	Бичиг баримтын зөрчилөөс эрх хязгаарлагдсан	Зөөврийн хайрцагаар санал өгөх ХБИ	Нэрсийн жагсаалтанд оруулсан
1	Архангай	101		101	
2	Баянхонгор	1506		105	15
3	Дундговь	542		20	
4	Дархан-Уул	1300		30	9
5	Увс	320	7	49	7
6	СХД	150	4		
7	БГД	100	3		
8	СБД	1000	18		
	Нийт	5019	32	305	31

Үйл ажиллагаа 3:

Сонгууль өгөх үйл явцад иргэдийн оролцоог хангах, сонгуулийн өдрийн үйл ажиллагаанд ажиглалт хийх

2012 оны 06-р сарын 27- 28-ны өдөр -Улаанбаатар хотын СХД, БГД, СБД-үүд болон Дархан-Уул, Архангай, Дундговь, Увс, Баянхонгор аймагт нийт 39 ажиглагч нар нийт 7 тойргийн хорооны 16 хэсгийн хороон дээр зөөврийн хайрцагаар санал авах үйл ажиллагаа болон сонгуулийн өдрийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа.

Зөөврийн хайрцагаар санал өгөх үйл ажиллагаанд онц ноцтой зөрчил гараагүй хэдий ч хуулийн тодорхойгүй заалт, хэрэгжилттэй холбоотой хэд хэдэн зөрчил гарлаа.

Эрхзүйн чадамжгүй иргэдийг тодорхойлсон дээд шүүхийн шийдвэр бичиг дийлэнхдээ гаргаагүй, болон уг хуулийн талаар хэсгийн хороодын ажилтанууд болон иргэд тодорхой мэдлэг, ойлголтгүйгээс эрхзүйн чадамжгүй иргэний гэр бүлийнхэнд нь итгэмжлэх олгон санал өгүүлэх, эсвэл эрхзүйн чадамжтай сэтгэцийн өөрчлөлттэй иргэдийг санал өгөх эрхийг хязгаарлах зэрэг зөрчилүүд гарлаа. Мөн сонгогчдын нэрсийн жагсаалтанд бүртгэгдээгүй, хаягийн өөрчлөлттэй, бичиг баримтын зөрчилтэй \иргэний үнэмлэхгүй\ гэсэн зөрчилүүд цөөнгүй гарч байв. Эрхзүйн чадамжгүй иргэдийн гэр бүлийнхэнд итгэмлэх олгон санал өгүүлж байгаа нь тухайн хүнд саналаа хоёр удаа өгөх боломжийг олгож хуулийг зөрчихөд хүргэж байв.

Зарим итгэмжлэгдсэг төлөөлөгч ХБ-тэй иргэний хэлсэнээс өөрөөр саналын хуудас дээр тэмдэглэгээ хийх оролдлого гаргаж байв.

Хэсгийн хороодын ажигтануудын дунд Иргэний нийгмийн ажиглагч нарын талаар мэдээлэл бага байсанаас намын, гадаадын ажиглагч нарт суудал, байрлал бэлдсэн хэрнээ иргэний нийгмийн ажиглагч нарт суудал бэлдээгүй байсан нь ажиглалтын явцад илэрсэн. Баянхонгор аймаг, Сүхбаатар дүүргийн тойргийн хороод манай ажиглагч нарыг бүхий л талаар дэмжин ажиллах боломжоор хангаж байв. Харин Дундговь аймагт автомат санал унших машины тайланг өгөхгүй байх, илүү гарсан саналын хуудсыг хайчлахгүйгээр ажиглагч нарыг гарсан бол Баянгол дүүргийн 25-р хэсгийн хороон дээр хурууны хээ уншигч машин гацах, камер тасалдсан зэрэг зөрчилүүд гарлаа.

Увс аймагт ажилласан төслийн баг ажиглалт хийх зөвшөөрөл авч чадаагүй ч сонгуулийн өдөр мониторинг хийн ажиллалаа. Мониторинг хийсэн ажиглагч нар сонгогчдод мөнгө тараах, буруу сурталчилгаа хийсэн зөрчилийг илрүүлэн, тойргийн хороонд мэдээлэн хүргэсэн байна.



СБ дүүрэг



Өвөрхангай аймаг



Сонгинохайрхан дүүрэг



Баянгол дүүрэг

Ажиглалтын үйл ажиллагааны тухай нэгдсэн дүн


	Аймаг дүүрэг	Ажиглагчийн тоо	Зөөврийн хайрцаг—ажиглагч	Ажиглалт хийсэн хэсгийн хороо	Гарсан зөрчилийн тоо	Гарсан зөрчил
1	Архангай	3		1-р тойрог 95 97 -р хэсгийн хороо		Зөрчилгүй
2	Баянхонгор	12	3	3-р тойрог 205, 208, 209, 211, 206, 215-р хэсгийн хороо.	3	Асран хамгаалагч өмнөөс нь санал өгөх оролдлого хийсэн.
3	Дархан-Уул	9	3	19-р тойрог 9, 4, 10-р хэсгийн хороо		Зөрчилгүй
4	Дундговь	9		8-р тойрог 44 45-р хэсгийн хороо		<ul style="list-style-type: none"> • Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг санал өгөх эрхийг хязгаарласан • Илүү гарсан саналын хуудасыг хайчлаагүй байхдаа ажиглагч нарыг гаргасан • Автомат саналын хайрцагны тайланг өгөөгүй
6	СХД	2	2	26-р тойргийн 56-р хэсэгт	5	<ul style="list-style-type: none"> • Сонгогчдын нэрсийн жагсаалтанд бүртгэгдээгүй. • Хаягийн зөрчилтэй. • Өндөр настай иргэд итгэлжлэл хийгээгүй, өмнөөс нь гэр бүлийн гишүүдээр саналын хуудас бөглүүлсэн. • Хурууны хээ таниулаагүйн улмаас . • Оршин суугаа хаяганд нь байхгүй иргэдийг бүртгэсэн гэх мэт нийтлэг зөрчлүүд ажиглагдаж байлаа.
7	СБД	2	2	23-р тойрог 17-р хэсгийн хороо	2	<ul style="list-style-type: none"> • Санал авах байрны гадна хэсэг хүртээмжгүй, налуу зам хийгдээгүй • Санал бэлтгэх бүхээгний хоорондын зай хэт ойр
8	БГД	2	2	25-р тойрог 24-р хэсгийн хороо	4	<ul style="list-style-type: none"> • Санал өгөх байрны гадаа үл мэдэгдэх хүмүүс иргэдийг цуглуулан уулзаж байсан. • Хэсгийн хорооны зарим хүмүүс сонгогчдын санал өгөх үйл явцад оролцож байсан. • Санал өгөх үеэр санал өгөх байрны камер тасалдсан. • 19:15 минутанд хурууны хээ уншдаг машин гацсан.
10	Увс аймаг				4	<ul style="list-style-type: none"> • Сонгогчдод мөнгө тараах үйлдэл гарсаныг илрүүлж тойргийн хороонд мэдэгдсэн

Formatted: Font: 10 pt

Formatted: Centered

Үйл ажиллагаа 4: ХБХ-ийн сонгуулийн оролцоог нэмэгдүүлэхэд тулгарч буй асуудлыг төр засаг олон нийтийн хэмжээнд тавьж шийдвэрлүүлэхэд нөлөөлөх, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хүргэх

Сонгуулийн шинэчилсэн хуульд ТББ, сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэхдээ сонгууль товлон зарласнаас хойш 15 хоногт багтаан хүсэлтээ ирүүлэн зөвшөөрөл авах ёстой гэсэн журмын дагуу Мерси Кор Монгол ОУБ болон тус байгууллагын орон нутаг дахь салбар зөвлөлийнхний оролцоотой Улаанбаатар хот, Өвөрхангай, Архангай, Дундговь, Увс, Дархан-Уул аймгуудын төсөлд оролцогч байгууллагуудад мэдээлэл хүргэж, байгууллагуудын албан хүсэлт ёс зүйн журмыг нэгтгэн 5 аймагт ажиллах 39 иргэний мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлж хяналт, ажиглалт хийх зөвшөөрлийг 2012 оны 5 сарын 22-ний өдөр Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо ТББ, Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Бизнес Инкубатор Төв ТББ гэсэн хоёр байгууллага авч, 05 сарын 28-ний өдөр Сонгуулийн ерөнхий хороотой харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд энэ нь цаашид манай төслийн бүхий л үйл ажиллагааг хуулийн хүрээнд үргэлжлэх боломжийг бий болгосон юм.



Төслийн хэрэгжих хугацаа харьцангуй бага, хамрах хүрээ болон хийгдэх ажил их байсан тул төслийн баг сонгуулийг шудрага явуулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төр, төрийн бус, олон нийтийн байгууллагуудтай хамтран, үйл ажиллагаагаа нэгтгэн ажиллахад анхааран ажилласан. Энэ зорилгын дагуу 2012 оны 05 сарын 24-ны өдөр **Сонирхогч талуудын уулзалтыг** зохион байгуулав. Тус уулзалтанд ХЗДХЯ-ны дэргэдэх Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо, ХЭҮК, СЕХ, СБТ, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Мерсикор Монгол ОУБ, Монфемнет Үндэсний Сүлжээ, ННФ болон ХБ-тэй иргэдийн ТББ-ууд, хэвлэл мэдээллийнхэн оролцож төслийн үйл ажиллагааны чиглэлтэй танилцахын зэрэгцээ, байгууллага бүр өөр өөрсдийн хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаагаа танилцуулж манай төсөлтэй хэрхэн уялдуулах, болон хамтарч ажиллах нөхцөлүүдийнхээ талаар нээлттэй ярилцлага өрнүүлсэн юм.


Уулзалтын үр дүнд

- ХБХ-ийг сонгуульд бүрэн дүүрэн оролцуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай ЗӨВЛӨМЖ боловсруулан СЕХ-нд хүргүүлэх
 - 2012 оны УИХ-ын сонгуульд оролцогч, намууд, нэр дэвшигч нарт хандсан ИЛ ЗАХИДАЛ-ыг боловсруулан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан хүргэх
 - Сонгуулийн ерөнхий хорооноос санал авах байрыг ХБХ-т хүртээмжтэйгээр засварлан сайжруулах чиглэлээр ажлын чиглэл гаргуулах
 - Санал авах машин, саналын хуудастай ажиллах аргачилалыг нийтэд хүргэх нэг өдрийн өдөрлөгийг Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулах
 - Харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэхэд зориулсан аудио номыг хэвлэн иргэдэд хүргэх
 - Сонгуулийн ерөнхий хорооноос гарах 1 брошурт санал авах байрны дэд бүтцийн стандартын талаарх мэдээлэлийг оруулах
 - ННФ-аас зохион байгуулж буй “Шудрага сонгуулийн төлөө гараа өргөцгөөе” залуусын аяны хүрээнд сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт мониторинг хийх ажилд ХБ-талаар асуумж оруулах
- зэрэг үйл ажиллагааг оролцогч талуудтай хамтран хийхээр зөвшилцөлд хүрлээ.



Сонирхогч талуудын уулзалтын дагуу төслийн баг “Хүртээмжтэй орчин” аяны ажлын хэсэгтэй хамтран 2012 оны УИХ, орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нам эвсэл болон нэр дэвшигч нарт хандсан Ил захидал, СЕХ-нд хүргүүлэх Зөвлөмжийг боловсруулан гаргав.

Зөвлөмжийг СЕХ-нд хүргүүлсэний дүнд СЕХ-ноос ХБХ-ийн сонгох эрхийг баталгаа:


“ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН - 2012
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН СОНГУУЛИЙН ТЭГШ ОРЛОЦОО” АЯН
 Улаанбаатар хот 2012 оны 05 сарын 24

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД ХҮРГЭХ ЗӨВЛӨМЖ

2012 оны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцоог хангах ажлыг эхлүүлсэнд талархан дараах үйл ажиллагааг анхааралдаа авч ажиллахыг хүсч Сонгуулийн Ерөнхий Хороонд “Хүртээмжтэй орчин 2012” аянд нэгдсэн байгууллагуудаас зөвлөмж хүргүүлж байна.

1. Саналын хуудсыг харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох, сул хараатай иргэд, бүтэн болон хагас саажилттай хүмүүс, өндөр настнууд, бичиг үсэггүй иргэдэд хүртээмжтэй байх үүднээс нэр дэвшигчийн зураг, намуудын лого-г саналын хуудсан дээр байршуулах, үсгийн фондыг 12-оос багагүй байлгах
2. Саналын хуудаст тэмдэглэгээ хийх аргачлал нь гарын ажиллагаа сул, саажилттай иргэд, өндөр настнуудын онцлогийг харгалзсан энгийн хялбар байх /эсвэл тусгай дардас ашиглуулах г.м .../.
3. Санал авах байрны дэд бүтцийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэйгээр тоноглон засах. Тухайлбал, санал авах байрууднэг давхарт байрласан байх, орц гарцандаа налуу замгүй байруудад зөөврийн налуу зам байрлуулах, саналын хуудас унших машины өндөр нь тэргэнцэртэй иргэнд тохиромжтой байх, санал тэмдэглэх бүхээгт сандал, томруулдаг шилийг байлгах гэх мэт. – илүү тодорхой болгох
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд удаан хугацаагаар зогсоход хүндрэлтэй байдгийг харгалзан үзэж санал авах байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг (итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хамт) дугааргүй оруулах, эсвэл тэдэнд зориулсан хүлээлгийн сандал тавих
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдарч буй харъяа хорооны ажилтан зөөврийн хайрцагар санал авах үйл ажиллагаанд оролцсоноор иргэнийг саналаа чөлөөтэй, хараат бусаар өгөхөд нөлөөлдөг төдийгүй, эсрэг санал өгсөн тохиолдолд хороо дүүргээс олгогддог халамжийн үйлчилгээнээс хасах зэргээр дарамталдаг тул тухайн хорооны засаг захиргааны нэгжийн албан хаагчдыг сольж ажиллуулах (оролцуулахгүй байх) гэх зэрэг арга хэмжээ авах.

6. Зөөврийн саналын хайрцгаар санал өгөхиргэдийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох эмч, эмнэлэгийн байгууллагын магадлагааг өрхийн эмчээс авах гэсэн нэгдсэн ойлголтыг тойрог, хэсгийн хороодын ажилтнуудад өгөх /зөөврийн саналын хайрцгаар санал авах журмын 2.2.2, 2.2.3/

Эдгээр зөвлөмжид үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох эрхийг баталгаажуулах, тэгш оролцоог хангахчиг үүргийгсонгуулийн бүх тойрог, хэсгийн хороодод өгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж буй ХБИ-ийн ТББ, ажлын хэсгүүдтэй идэвхитэй хамтран ажиллахыг Сонгуулийн Ерөнхий Хорооноос хүсье.

“Хүртээмжтэй орчин 2012 – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуулийн тэгш Оролцоо” аянд нэгдэн орсон байгууллагууд:

1. Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Бизнес Инкубатор Төв
2. Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо
3. Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо
4. Монголын Дүлий Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо
5. Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Чөлөөт Үйлдвэрчний Эвлэл
6. Сонсголын Бэрхшээлтэй Иргэдийн “Дэмжих гар” ТББ
7. Тархины Сааны Холбоо
8. Тэгш Нийгэм ТББ
9. Айвуун ТББ
10. Түгээмэл Хөгжил Төв ТББ
11. Дүлий Залуучуудын Холбоо
12. Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Нийслэлийн Зөвлөл
13. Сонгинохайрхан дүүргийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Холбоо
14. Сүхбаатар дүүргийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Холбоо
15. Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Эрхийн Үндэсний Төв
16. Чингэлтэй дүүргийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Холбоо.
17. Багануур дүүргийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Холбоо.
18. Багахангай дүүргийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Холбоо.
19. Налайх дүүргийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Холбоо.
20. Хүний Эрхийн Хэрэгжилтийг Хангах Үндэсний Хороо.
21. Хүний Эрхийн Үндэсний Комисс.
22. Мерси Кор Монгол Олон Улсын Байгууллага.
23. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр.
Эрхзүйн чадавхийн нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулах нь төсөл
24. Сонгогчын боловсрол төв.



2012 ОНЫ УИХ, ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧ НАМ ЭВСЭЛ БОЛОН НЭР ДЭВШИГЧ ТАНД ХҮРГЭХ ИЛ ЗАХИДАЛ

2012 оны 5-р сарын 24 Улаанбаатар хот

Улс эх орны хөгжил дэвшил, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэгч, УИХ, орон нутгийн сонгуульд нэр дэвшигч танд энэ өдрийн мэнд дэвшүүлж амжилт хүсье.

Монгол Улс НҮБ-аас батлан гаргасан Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Эрхийн тухай конвенцид нэгдэн орж дээрх иргэдийг улс төр, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцдог нийгмийг цогцлоон бүтээх үүрэг хүлээсэн. Энэ үйл явцыг тохиолдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд нэгдэн конвенцийн хэрэгжилтийг хангах, тулгамдаж буй асуудлаа нийтэд хүргэх "Хүртээмжтэй орчин аян"-ыг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай. Сонгуулийн жилтэй холбогдуулан аяныг **"Хүртээмжтэй орчин 2012 – Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Сонгуулийн Тэгш Оролцоо"** уриан дор зохион байгуулж байна.

Нэр дэвшигч та өөрийн мөрийн хөтөлбөрийг сонгогчдод хүргэхдээ сонсгол, харааны бэрхшээлтэй иргэд болон удаан ойлгоцтой, саажилттай хүмүүст хүртээмжтэйгээр зохион байгуулбал хүн бүрт хүрнэ. Тухайлбал, мэдээллийг дохионы орчуулагчаар дамжуулах, дүрс өгүүлэмж, аудио видео хэлбэрийг ашиглах, брайлиар хэвлэх зэргээр аль болох хүртээмжтэй загварыг ашигланбүх хүмүүст алагчлалгүй хандахыг эрхэмлэнэ үү.

Таны нэр дэвшиж буй тойргийн хэсгийн хорооны санал авах байр **"УИХ-ын сонгуулийн хэсгийн хорооныболон санал авах байрыг бэлдэх заавар"**-ын 3.3 заалтын дагуу тоноглогдсон эсэхийг шалган үзэж биелэлтийг хангахад анхаарал хандуулах нь:


Төрийн түшээ болох таны **"НҮБ-ын Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Эрхийн Тухай Конвенц"**-ийн 29-р зүйлийн биелэлтийг хангахад оруулж буй хувь нэмэр болох билээ.

Монгол улсад амьдарч буй 130мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хүндэтгэн мэдээлэл сурталчилгаагаа хүртээмжтэй байдлаар хүргэсэн нэр дэвшигч таныг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдгээрийн гэр бүл, найз нөхөд талархан дэмжих болно.

ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН 2012-ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН СОНГУУЛИЙН ТЭГШ ОРОЛЦОО" АЯНААС

Нэр дэвшигч намуудад хүргэх ил захидлыг өдөр тутмын "Өнөөдөр" , "Өдрийн сонин"-ны 1-р нүүрэн гаргаж, ХЭҮК-ийн вэб сайт дээр байршуулан олон нийтэд хүргэхийн зэрэгцээ хэвлэлийн бага хурал зохион байгуулах замаар хэвлэл мэдээллийнхэнд болон олон нийтэд хүргэлээ.

СЕХ-ноос сонгуулийн тойргийн хороодод хүргэсэн ажлын чиглэл



Энэхүү ажлын чиглэл нь төслийн үйл ажиллагааг үр дүнтэй, эрчимтэй явагдахад чухал түлхэц болсон.

Ажлын чиглэл бүх тойргийн хороодод хүргэгдсэний дараанаас орон нутаг дахь төслийн багууд идэвхитэй үйл ажиллагаагаа эхлүүлж, тухайн орон нутгийн засаг захиргааныхан болон хэсгийн хороодтой уулзалт зохион байгуулж, төслийн үйл ажиллагаагаа танилцуулан хамтран ажиллах нөхцөлөө тодорхойлсон.

Төслийн багууд сонгуулийн тойргийн хороодтой уулзалт зохион байгуулан төслийн зорилгыг танилцуулж, хамтран ажиллах нөхцөлөө тодорхойлов.



Дархан-Уул аймаг



Баянхонгор аймаг



Дундговь аймаг

Увс аймаг

Хэсгийн хороод, болон орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн уулзалтаар төслийн багууд дараах хэд хэдэн чиглэлээр хамтран ажиллах санал тавьсан.

- Хүртээмжтэй орчин аяны хүрээнд СЕХ-ноос гаргасан 2012 оны 06 сарын 22-ны өдрийн 333 тоот ажлын чиглэлийн хэрэгжилтийг ханган ажиллах
- Сонгуулийн өдөр ажиллах ажиглагч нарыг танилцуулж зөвшөөрөл авах
- Иргэдийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх сургалт сурталчилгааны ажлыг хамтран хэрэгжүүлэх,
- Санал авах байрны хүртээмжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах

Сонгуулийг шудрага, нээлттэй явуулах, иргэдийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, ХБХ-ийн сонгуулийн оролцоог нэмэгдүүлэхэд тодорхой ажил хийхээр зорьж буй төслийн багийнхныг сонгуулийн тойргийн хороод болон, орон нутаг, дүүргийн албан хаагч нар ихэнхдээ талархан нааштайгаар хүлээж авч, аль болох дэмжин хамтран ажиллахаа илэрхийлсэн юм.

Гэхдээ зарим ажилтан, албан хаагч нар ХБХ-ийг үл тоомсорлох, үл итгэх, намуудын ажилтан нартай андуурч ойлгох хүндрэлүүд гарч байв.

Туршилтын санал өгөх нөлөөллийн үйл ажиллагаа.

2012 оны УИХ-ын сонгууль мажоритар, пропорциональ хосолмол тогтолцоогоор явагдах болсон, сонгуулийн санал хураах, тоолох ажлыг автоматжуулсан төхөөрөмжөөр гүйцэтгэх, анх удаа УИХ, орон нутгийн сонгууль зэрэг явагдах зэрэг олон онцлог талуудтай болж байгаатай холбогдуулан нийт иргэдийн дунд олон зөрүүтэй ойлголт бий болсон, санал унших машинтай хэрхэн ажиллахаа мэдэхгүй байгаа нь ажиглагдаж байсан

тул **Туршилтын санал өгөх** нэг өдрийн компани ажлыг СЕХ-той хамтран 2012 оны 06 сарын 24-ны өдөр Тусгаар тогтнолын талбай дээр зохион байгуулав.

Туршилтын санал өгөх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа талбайн хэсгийг санал авах байртай адил болгон тохижуулсан бөгөөд сонирхсон иргэд сонгуулийн өдөр ямар дарааллаар яаж саналыг өгөх тухай аргачилсан зааварчилгаа авсан юм. Туршилтын үйл ажиллагаанд 2012 оны УИХ-ын сонгуульд анх удаа ашиглагдах санал тоолох 2 машиныг ашигласан нь үйл ажиллагааг илүү бодитой үр дүнтэй болгосон юм. Туршилтын санал өгөх үйл ажиллагаа СЕХ-ны дарга Лувсанжав нээж, Мерсикор Монгол ОУБ-ын захирал Jennifer L. Butz мэндчилгээ дэвшүүлсэнээр эхэлсэн юм.

Нээлт



СЕХ-ны дарга Н. Лувсанжав



Туршилтын санал өгсөн иргэд зөвлөгөө мэдээллийн хэсгээс саналын хуудас дээр зөв тэмдэглэгээ хийсэн эсэх, санал тоолох машинтай зөв харьцсан эсэх тухайгаа мэдэхийн зэрэгцээ ямар хүндрэл бэрхшээл гарч байгааг хэлж байв.



Иргэдэд зөвлөгөө өгч байна



Сонгогчийн боловсролыг дээшлүүлэх гарын авлаг материал тарааж байна



Туршилтын санал өгөх үйл ажиллагаанд иргэд оролцож байна.



Харааны бэрхшээлтэй иргэд

Энэхүү үйл ажиллагаанд харааны, сонсголын, хэл ярианы бэрхшээлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон, Тусгаар тогтнолын талбай дээр зорчиж байсан бусад иргэд нийтдээ 560 гаруй хүн хамрагдсан юм. Үүнээс 176 нь туршилтын санал өгөх үйл ажиллагаанд оролцсон бол 384 хүнд зөвлөгөө мэдээлэл авсан байлаа.

Үйл ажиллагааны зохион байгуулалтанд Хүртээмжтэй орчин аянд нэгдсэн ХБХ-ийн ТББ-ын 25 төлөөлөл, 30 сайн дурын ажилтан, Мерсикор Монгол ОУ-ын байгууллагын Иргэдийн оролцоо Засаглалын хөтөлбөрийн хамт олон зэрэг нийт 56 хүн ажилласан.

СЕХ, СБТ, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ТББ зэрэг байгууллагууд дэмжин ажиллаж, сонгогчдийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр гаргасан гарын авлага, тараах материалуудыг иргэдэд хүргэх ажлыг хийж байв. Нөлөөллийн ажлын үеэр нэр дэвшигчид, намууд өөрийн сурталчилгаагаа хийх, цугларсан олны дунд намуудын сурталчилгааны материал тараах зэрэг оролдлого хийжээр завдаж байсан нь зохион байгуулагчидад хүндрэл үүсгэж байв. Гэсэн хэдий ч төслийн баг энэ байдлыг урьдаар харж зөвхөн иргэдийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа болохыг иргэдэд зөвөөр хүргэх, аль нэг нам, нэр дэвшигчийн сурталчилгаатай хамааралгүй байлгах урьдчилсан арга хэмжээг бэлтгэл ажлын хүрээнд сайтар ханган ажиллаж чадсан байснаараа давуу талтай байлаа. Жишээ нь бид туршилтын саналын хуудас дээр ямар ч намын нэр тавиагүй бөгөөд, саналын хуудасыг туршилтын гэсэн тодотголтойгоор хэвлэж үйл ажиллагаандаа ашигласан.




Санал бэлтгэх бүхээг



Санал тоолох машин

Туршилтын санал өгөх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд иргэд саналын хуудас, санал тоолох машинтай ажиллахад гарч буй нийтлэг алдаа, сонгуулийн шинэчилсэн хуультай холбоотой гарч буй иргэдийн буруу ташаа ойлголтын талаарх мэдээллийг нэгтгэн дүгнэлт гаргаж, СЕХ болон бусад сонирхогч талуудад хүргэх ажлыг зохион байгуулж, цаашид анхаарах, авч хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг тодорхой болгов

Сонгуулийн шинэ хуультай холбоотой гарч буй нийтлэг зөрүү ойлголт



2012 оны Монгол Улсын Их Хурлын Сонгууль нь мажоритар, пропорциональ хосолмол тогтолцоогоор явагдаж байгаатай холбогдуулан, иргэдийн дунд олон эргэлзээ байв. Жишээ нь: Хоёр мандаттай тойргоос хоёр нэр дэвшигч, нэг намыг сонгох ёстой. Гэтэл нэр дэвшигч, намуудын тоо тэнцүү байна гэсэн буруу ойлголт, мөн өөрийн сонгосон нэр дэвшигчийн харъяалалын намыг сонгоно, хэдэн ч мандаттай байсан хамаагүй зөвхөн нэг л нэр дэвшигчийг сонгоно гэсэн зөрүү ойлголтууд олон байлаа.

Бидний санаачилсан туршилтын санал өгөх үйл ажиллагаа нь цаг үеэ олсон, маш үр өгөөжтэй үйл ажиллагаа боллоо гэж СЕХ үнэлсэн юм.

Саналын хуудас тэмдэглэхтэй холбоотой гарсан нийтлэг асуудал

- Үзээний үзүүр бүдүүн байгаагаас саажилттай болон, өндөр настан, сүл хараатай иргэд зуралт нь сүүлтэй болж байгаа
- Саналын хуудсыг нугалах
- Үсгийн хэмжээ жижиг байгаа тул томруулдаг шил заавал хэрэгтэй байв

Саналын хуудас дээр тэмдэглэгээ хийх үед ХБХ-т тулгарч буй нийтлэг бэрхшээлийг нэгтгэн СЕХ-нд танилцуулсаны дүнд СЕХ-ноос гаргасан 123-р тогтоолд Иргэд саналын хуудас дээр саналаа тэмдэглэхдээ нэр дэвшигчийн өмнөх дугуй дүрсний 3/1-ийг ямар нэг байдлаар тэмдэглэсэн байхад хүчинтэй тооцох шинэ журмыг оруулж чадсан.

2012 оны УИХ-ын сонгуулийн үйл явцад ХБИ-дийн ТББ-уудаас хийсэн мониторинг, туршлага солилцох зөвлөгөөн

2012 оны 07 сарын 05-нд манай төслийг хэрэгжүүлсэн 6 аймгийн төслийн баг, Улаанбаатар хотод ажилласан ХБХ-ийн ТББ-ууд болон 2012 оны УИХ-ын сонгуульд мониторинг, хяналт хийн ажилласан бусад иргэнийн нийгмийн байгууллагуудыг оролцуулсан “Туршлага солилцох зөвлөгөөн”-ийг зохион байгуулав.

Туршлага солилцох зөвлөгөөнөөр төсөл хэрэгжүүлсэн 6 аймаг, Улаанбаатар хотын төслийн баг төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлангаа танилцуулж, ололт амжилт, тулгарсан бэрхшээл, цаашид хийж хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын санал дүгнэлтээ оролцогчидод танилцууллаа. Мөн ННФ –ийн судлаачид хийсэн мониторингийн дүнгээ танилцуулж, өөрсдийн туршлагаа хуваалцлаа.

Зөвлөгөөний нээлтэнд төслийг санхүүжүүлэгч Мерсикор Монгол ОУ-ын байгууллагын суурин төлөөлөгч Женифер оролцож төсөл хэрэгжүүлэгч орон нутгийн төлөөллийнхөнд баяр хүргэв.

Зөвлөгөөнд оролцогчид төслийн хэрэгжилтийн тайлангаа тавьж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой асуулт хариулт өрнүүлж санал бодлоо нэгтгэлээ. Үүний дараа зөвлөгөөнд оролцогчид дараа дараачийн сонгуульд юуг анхааран ажиллах, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа тухай саналуудаа нэгтгэхээр багаар ажилласан юм.

Багийн ажлын дүнд хууль эрхзүйн хүрээнд хийх өөрчлөлт, хяналт мониторинг хийх үйл ажиллагаанд хийх өөрчлөлт, бусад хүмүүсийн харилцаа, хандлагыг өөрчлөхөд хийх өөрчлөлтүүдийг жагсаалтаар гарган СЕХ, болон бусад хууль тогтоогч нарт Зөвлөмж болгон хүргүүлэх шийдвэрт хүрлээ

Семинарын зураг

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хүргэх.

1. Хүртээмжтэй орчин 2012 аян болон төслийн үйл ажиллагааг танилцуулах хэвлэлийн бага хурлыг 2012 оны 06 сарын 15-нд хэвлэлийн хүрээлэнд зохион байгуулж 10 телевиз, 1 сайтаар мэдээллийг олон нийтэд хүргэв.

ТВ-үүд : UBS, Eagle, Olooo, BTV, Шинэ дэлхий, Шонхор, ТВ 8, ТВ 9, ТВ 5, Шууд телевиз

Сайт : Time.mn сайт оролцов

2012 оны 06 сарын 12-нд ХЭҮК-ын захиалгаар бэлтгэгдэн МҮОНТ-ээр цацагдсан “Сонгох, сонгогдох эрх” ТВ-ийн 20 минутын нэвтрүүлэгт оролцож төслийн үйл ажиллагаа, зорилгын талаар мэдээлэл хийв.

2012 оны УИХ, орон нутгийн сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигч нарт хандан гаргасан Ил захидлыг 2012 оны 06 сарын 19-ны өдрийн Өнөөдөр сонины 1- нүүрэнд нийтлэн олон нийтэд хүргэсэн бол Баянхонгор аймгийн Баянхонгор Таймс сонинд үйл ажиллагааны талаар мэдээлэл нийтлэв.

Мөн аяны хүрээнд ХБ хүмүүсийн сонгуулийн тэгш оролцоо 20 минутын ТВ нэвтрүүлэг бэлтгэн 2012 оны 06 сарын 25-нд МҮОНТ-ээр цацагдлаа.

2012 оны 06 сарын 22-нд Монгол Ньюс хэвлэлийн хүрээлэнд дахин хэвлэлийн хурал зарлаж төслийн үйл явц болон санал авах байрны хүртээмж, нэрсийн жагсаалтанд тулгалт хийсэн ажлын тайланг танилцуулж, туршилтын санал өгөх үйл ажиллагааны товыг зарлав.

Сонгуулийн өдөр буюу 2012 оны 06 сарны 28-ны өдөр буюу сонгуулийн өдөр Ийгл телевизийн “Election Box” ярилцлагын цагт оролцож төслийн үйл ажиллагааг танилцуулахын зэрэгцээ, СЕХ-ноос гаргасан 123-р тогтоолийн олон нийтэд танилцууллаа.

Мөн төслийн үйл ажиллагаа, үр дүн, болон туршилтын санал өгөх нөлөөллийн ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий 15 минутын баримтат киног хийлгэлээ.

Дархан-Уул аймагт ХБХ-ийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх сургалтын талаар 4 ТВ-ээр мэдээлэв, Увс аймагт 10 минутын ТВ нэвтрүүлэг хийгдэн 3 удаа орон нутгийн ТВ-гээр цацагдсан бол Дундговь аймагт сонгуулийн оролцлоог дэмжсэн шторкийг 10 өдрийн турш нэвтрүүлж, 1 сурталчилгааны самбар байршуулан иргэдийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, төслийн үйл ажиллагааг сурталчилах ажлыг хэрэгжүүлэв.

ТУЛГАРСАН БЭРХШЭЭЛ, СУРГАМЖ

Төсөл нь төлөвлөсөн хугацаанаас оройтож эхэлсэн нь төслийн хэрэгжилтэнд нөлөөлж, эхний хийгдсэн ажлын үр дүнг харалгүйгээр дараагийн ажлыг эхлүүлэхээс аргагүйд хүрэх хүндрэлүүд гарч байв.

Зөөврийн хайрцагаар санал өгөх үйл ажиллагаанд ажиглалт хийхдээ журмын дагуу өөрийн унаагаар явсан хэдий ч алслагдсан дүүрэг , орон нутгийн ажиглагч нарын унааны зардал нь хүрэлцээгүйн улмаас бусад намын машинд дайгдахаас аргагүй байдалд орох бэрхшээл тулгарч байв.

Мөн Өвөрхангай аймагт ажилласан төслийн баг ХБХ-ийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх сургалтын зараа нам, эвсэлүүдийн ухуулгын байр, ухуулагч нараар дамжуулан түгээлгэсэн алдаа гарсан юм. Уг асуудлын дагуу Өвөрхангай аймгийн Ардчилсан намын сонгуулийн штабаас тус аймгийн эрхзүйн чадамжтай ХБХ-ийг хамрах сургалт бүрэн явагдаж чадаагүй. Энэ нь төсөл хэрэгжүүлэгчидийн хувьд томоохон сургамж болж, аливаа үйл ажиллагааг зохион байгуулахдаа улс төрийн нам, эвсэлээс ангид байхын чухалыг ойлгуулсан.

Зарим аймаг дүүргийн засаг дарга нар, нийгмийн ажилтууд, сонгуулийн тойрог хороодын ажилтанууд ХБИ –ийн талаарх мэдлэг ойлголт хангалтгүйгээс төслийн багийнханд үл итгэх, үл тоомсорлох, хандлага гаргаж байв. Жишээ нь сонгуулийн өдөр нам эвсэлүүдийн ажиглагч нарт суудал бэлдсэн хирнээ, иргэний нийгмийн ажиглагч нарт бэлдээгүй байсан тохиолдол олон гарсан.

Төслийг хэрэгжүүлэхдээ ХБХ-ийн сонгуулийн оролцоонд голлон анхаарч ажилласан. Гэсэн хэдий ч зарим хэсгийн хороод санал авах байрыг хүртээмжтэй болгохгүйгээр тухайн хэсгийн хороонд байх бүх ХБХ-ийг саналын зөөврийн хайрцагаар авахаар зохион байгуулсан алдаатай үйлдэл гарсан юм. Энэ нь сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулагч нарын хүндрэл бэрхшээлийг хөнгөвчлөх гэсэн муу хандлага төдийгүй цаашид энэхүү алдааг засах сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулах шаардлагатай болохыг харуулж байна.

Formatted: Justified, Don't adjust space between Latin and Asian text

ДҮГНЭЛТ

“ХБХ-ийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх замаар оролцоог нэмэгдүүлэх нь” төсөл нь ХБХ-т анх удаа өөрсдийн Улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг баталгаажуулахад анхаарал хандуулан, дуу хоолойгоо нэгтгэн хамтран ажиллах боломжийг олголоо. Төслийн бүхий л үйл ажиллагаа ХБХ-ийн санаачлага, оролцоо, үйл ажиллагаан дээр суурилан хэрэгжүүлсэнээрээ бусад төсөл хөтөлбөрүүдээс онцлогтой байлаа хэмээн төслийн баг дүгнэж байна.

Төсөл нь Өвөрхангай, Архангай, Дундговь, Увс, Дархан-Уул, Дундговь аймаг болон Улаанбаатар хотыг хамран хэрэгжсэн бөгөөд дээрх аймаг, хотод байх ХБХ-ийн ТББ-уудын дунд төслийн уралдаан зарлах замаар төсөл хэрэгжүүлэгч нарыг сонгон шалгаруулсан. Төсөлд дээр дурдсан аймаг хотуудын 26 ТББ хамрагдаж, аймаг дүүргээр хуваагдан 7 баг болж ажилласан.

Сонгуулийн шинэчилсэн хуульд ТББ, сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэхдээ зөвшөөрөл авах ёстой байх журмын дагуу СЕХ-нд хүсэлт тавьж 5 аймагт ажиллах 39 ажиглагчийг бүртгүүлж, Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо ТББ, Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Бизнес Инкубатор Төв ТББ-ууд хяналт, шинжилгээ хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэх зөвшөөрөл авсан нь цаашид төслийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд үргэлжлэх боломжийг бий болгосон юм. Мэргэжлийн байгууллагуудын оролцоотой, төслийн багийнханыг сонгуультай холбоотой хууль эрхзүйн мэдлэг олгох, сонгуулийн үйл ажиллагаанд хяналт мониторинг хийх аргачилалд сургах, 2012_оны УИХ-ын сонгууль, сонгуулийн шинэчилсэн хуулийг таниулах сургалтанд хамруулж чадваржуулав. Төслийн хүрээнд 672 ХБ-тэй иргэнийг хамруулсан байна. Нэг ХБХ цаана тэдгээрийн гэр бүл давхар мэдээллээр хангагдсан гэж тооцвол төслийн үйл ажиллагаа 2688 хүнд хүрчээ. Сургалтанд хамрагдсан иргэдээс орон нутаг, дүүрэг бүрт идэвхтэн туслагч нарын бүлгийг байгуулав. Нийт 72 идэвхтэн туслагч нарын оролцоотой санал авах байрыг хүртээмжтэй болгоход нөлөөлөх, хэрэгжилтэнд үнэлгээ хийх, шаардлагатай мэдээллээр хангах, сонгогчийн нэрсийн жагсаалтанд тулгалт хийх, зөөврийн хайрцагаар санал өгөх ХБХ-ийн нэрсийг хэсгийн хороодод хүргэх, сонгогчдод санал авах байрны байршил, саналын хуудас дээр хэрхэн тэмдэглэгээ хийх, сонгуулийн шинэчилсэн хуулийн талаарх мэдээллийг танхимын сургалт, гэрээр очих, орон нутгийн хэвлэл мэдээллийг хэрэгсэл ашиглах, брошур, ном хэвлэх зэрэг

нөлөөллийн олон аргыг ашиглан иргэдэд хүргэх ажлуудыг амжилттай зохион байгууллаа.

Сонгууль зарлагдсанаас хойш 1 сарын дараа хийсэн санал авах байрны хүртээмжийн үнэлгээгээр санал авах байруудын 15%-нь хүртээмжтэй байсан бол, сонгуулийн өдөр хийсэн үнэлгээгээр 47,6%-нь хүртээмжтэй болж үзүүлэлт 32,6%-иар сайжирсан нь төслийн нөлөөллийн ажлын үр дүнг харуулж байна.

Орон нутаг, дүүргийн ХХҮХ, Нийгмийн даатгалын хэлтэс, өрхийн эмнэлэг болон ХБХ-ийн ТББ-уудад байгаа нэрсийн жагсаалтанд тулгуурлан нийт 5019 ХБ-тэй сонгогчийн нэрсийн жагсаалтанд тулгалт хийв. Ажлын явцад бичиг баримтын зөрчилийн улмаас сонгуульд оролцох эрх үүсээгүй 32 ХБ-тэй иргэдийг илрүүлэв. Орон нутгийн 4 аймагт нийт зөөврийн хайрцагаар санал өгөх 305 иргэний бүртгэлийг хэсгийн хороодод хүргүүлэн ажиллалаа.

Сонгуулийн өдөр 39 ажиглагч нар 18 хэсгийн хороо, 12 зөөврийн хайрцаг дээр ажиглалт хийн ажиллав. Ажиглагч нар нийт 16 зөрчилийг илрүүлж, тойргийн хороонд мэдээлэн хүргэсэн байна.

Хүртээмжтэй орчин аяны ажлын хэсэгтэй хамтран 2012 оны УИХ-ын сонгуульд ХБХ-ийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 6 заалт бүхий Зөвлөмж боловсруулан СЕХ-нд хүргүүлсэний дагуу 2012 оны 6 сарын 02-ны өдөр СЕХ-ноос 3 заалт бүхий ажлын чиглэл гарган Монгол Улсын Их Хурлын 2012 оны сонгуулийн 1069 тойргийн хороонд хүргүүлсэн нь төслийн гол үр дүн байв. Мөн нэр дэвшигч нар болон нам, эвсэлүүдэд хандсан Ил Захидлыг боловсруулж хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан иргэдэд хүргэснээр ХБХ-ийн сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх талаарх олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөх нөлөөлөлийн ажил болсон юм.

2012 оны сонгуулийн шинэлэг байдал, сонгуулийн санал хураах, тоолох ажлыг автоматжуулсан төхөөрөмжөөр гүйцэтгэх зэргээс хамааран иргэдийн дундах зөрүүтэй ойлголт их байсан тул СЕХ-той хамтран Туршилтын санал өгөх 1 өдрийн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж 560 хүнийг хамруулж, мэдээлэл зөвлөгөө өгөв. Мөн саналын хуудас, санал тоолох машинтай иргэд ажиллах үед нийтлэг гарч буй алдаа, санал өгөхтэй холбоотой буруу ойлголтуудыг нэгтгэн СЕХ-нд танилцуулсаны дүнд СЕХ-ноос гаргасан 123-р тогтоолд Иргэд саналын хуудас дээр саналаа тэмдэглэхдээ нэр дэвшигчийн өмнөх дугуй дүрсний 3/1-ийг ямар нэг байдлаар тэмдэглэсэн байхад хүчинтэй тооцох гэсэн шинэ журмыг оруулж чадсан үр дүнтэй ажил болов.

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын дунд туршлага солилцох зөвлөгөөнийг зохион байгуулж, төслийн үр дүнг нэгтгэн дүгнэхийн зэрэгцээ

дараа, дараагийн сонгуульд анхаарах, авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг нэгтгэсэн Зөвлөмж боловсруулж бусад иргэний нийгмийн байгууллагуудын хамт ХЭҮК, СЕХ, ХЗДХЯ, УИХ-ын тамгийн газар, Ерөнхийлөгчийн тамгын газар, МУ-ын дээд шүүх зэрэг байгууллагуудад хүргүүлсэний дүнд “Аймаг, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулинд дараах 4 заалт орсон.

9.5.Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг,зорилт бүхий төрийн бус байгууллага нь сонгуулийн хороод болон сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, түүнд эрхээ хэрэгжүүлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх, сонгуулийн үйл явцыг ажиглах зэргээр сонгуулийг хуулийн дагуу,шударгаар явуулахад туслалцаа үзүүлэх эрхтэй.

46.3.3.зөвөрийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал өгч байгаа сонгогчоос саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг;

46.8.Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэхболомжийг хангасан, хэсэг дэх сонгогчдын тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.

51.1.Санал авах байранд хүрэлцэн ирж чадахгүй дараах сонгогчийн саналыг түүний хүсэлт, эмнэлгийн магадлагаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн зөвөрийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал авах өдрийн өмнөх өдөр авна:

Дээрх бүх үйл ажиллагааны дүнд ХБХ-ийн сонгуулийн оролцоо 2008 оны сонгуулийн үеийнхээс 35,3% -иар нэмэгдэж 67,4%-т хүрсэн бол санал авах байрны хүртээмж 15%-иас 47,6% хүртэл нэмэгдэж 32,6% -аар сайжирсан байна.



Төслийн бүхий л үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилахад анхааран ажилласан бөгөөд, төслийн хүрээнд 2 телевизийн нэвтрүүлэг, 1 баримтат кино, 2 сонины нийтлэл, 2 удаагийн хэвлэлийн хурал зохион байгуулж, 4 ярилцлага, 14 мэдээгээр үйл ажиллагааг олон нийтэд хүргэв.

Мөн манай төсөл нь ХБХ-ийн улс төрийн эрхийг баталгаажуулах чиглэлээр хэрэгжсэн анхны томоохон үйл ажиллагаа болсон бөгөөд, орон нутгийн 6 аймгийн ХБХ-ийн ТББ-ын анхаарлыг нэгэн зорилго, үйл ажиллагааны дор богино хугацаанд нэгтгэсэн анхны сүлжээ төсөл байсанаараа онцлогтой байв. Үүний үр дүнд орон нутаг дахь ТББ-дын нэр хүнд өсч төрийн байгууллагуудад үнэлэгдэж эхэлсэн байна.

Төслийн үр дүнд шудрага сонгууль явуулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр нөлөөлөх, ажиглалт, мониторинг хийх чадвар бүхий багууд бий болж төлөвшсөн бөгөөд дээрх иргэдийн оролцоотой орон нутгийн сонгуульд ХБХ-ийн оролцоог сайжруулах чиглэлээр дахин нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, алдааг залруулах, ХБ-тэй сонгогчийн боловсролыг дээшлүүлэх ажил зохион байгуулах шаардлагатай хэмээн төслийн баг дүгнэж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Сонгогчийн нэрсийн жагсаалтыг гаргахдаа эрхзүйн чадамжгүй иргэдийн мэдээллийг дээд шүүхээс авч хэсэг тойргийн хороодод хүргэн, тэдгээр иргэдийг сонгогчийн нэрсийн жагсаалтаас хасах гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлж асран хамгаалагчдын давхар санал өгөх үйлдлийг зогсоох.
2. Санал авах байрны хүртээмжтэй байдлын стандарт гарган подваль болон хоёроос дээш давхарт байршуулахыг хориглох.
3. Зөөврийн хайрцагаар санал өгөх үйл ажиллагаанд тухайн хорооны дарга, нийгмийн ажилтанг сольж явуулан, санал авах явцад хаалт, бүхээг ашиглах
4. Мэдээлэл авахад бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн сонгогчийн боловсролын зардлыг сонгуулийн төсөвт суулгах
5. Брайль саналын хуудас хэвлэх, шоблом ашиглах, болон орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглах замаар харааны бэрхшээлтэй иргэдийн сонгуульд оролцох эрхийг баталгаажуулах.
6. ЕБС-ийн сургуулийн эрхзүйн хичээлийн хөтөлбөрт
 - Сонгогчийн эрх үүрэг
 - Санал авах дараалал
 - Сонгогчдод хориглох зүйл
 - Хүчинтэй хүчингүй тэмдэглэгээ зэрэг сонгуулийн хууль, дүрэм, журмууд зэрэг мэдээллийг оруулах.

Тайлан бичсэн:

Төслийн зөвлөх: Б.Чулуундолгор

Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо

bchuluundolgor@yahoo.com

Phone 99834457; 89982929
